/БОАЖС, СС-ын хамтарсан 2018 оны А/70/56 тоот тушаалаар хүчингүй болсон/

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах / 1995 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатархот Дугаар 169/171 Усны тухай Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 5 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь; 1. "Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах" журмыг хавсралт ёсоор баталсугай. 2. "Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах" журмыг 1996 оны 1 дүгээр сард багтаан Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргэх ажлыг зохион байгуулахыг Байгалийн нөөцийн газар (Д. Мөнхбаатар)-т даалгасугай, 3. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагуудад үүрэг болгосугай. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД Ц. АДЬЯАСҮРЭН САНГИЙН САЙД Ч. УЛААН 1996 оны 1-р сарын 27-ны өдрийн улсын бүртгэлийн 850 дугаарт бүртгэсэн.